

**БАТЛАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХБОБХГ-ЫН
ДАРГА**

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН “ХАНГИ ЭКО ЛОГИСТИК” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.БЯМБАСҮРЭН



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН ХАНГИ БООМТОД ХИЛ
ДАМНАСАН ОЛОН ТӨРӨЛТ ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН УХААЛАГ
СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/РЕГИСТРИЙН ДУГААР - 6980015/**

**ХЯНАСАН: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ШИНЖЭЭЧ**

БОЛОВСРУУЛСАН:

**ХАНГИ ЭКО ЛОГИСТИК ХХК-ИЙН ХАБЭА-БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
..... Ц.МӨНХТҮВШИН**

2025 ОН

АГУУЛГА

1.ТӨСВИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн мэдээлэл	3
1.4. Төсөл хэрэгжүүлэх шаардлага, шалтгаан	4
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Газарзүйн мужлал.....	5
2.2. Уур амьсгал	5
2.3. Агаарын чанар	5
2.4. Гадаргын ус	5
2.5. Газрын доорх ус	5
2.6. Хөрс	6
2.7. Ургаамал	6
2.8. Амьтан	6
2.9. Нийгэм, эдийн засгийн байдал	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	
3.1. Төслийн гол зорилт	6
3.2. Цар хүрээ, хэмжээ	7
3.3. Төсөл захиалагч байгууллагын хаяг	7
3.4. Төслийн байршил	7
3.5. Төсөл хэрэгжсэнээр	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	
4.1. Төслийн байгаль орчны төсөө	8
4.2. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9-12
4.3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
4.4. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15-17
4.6.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	18-19
4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20-22
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	22-24
6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	24-25

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харьяалал.

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Тус төсөл нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэр 4-р “Сулинхээр” баг “Ханги”-н боомт дээр хэрэгжинэ. Тус боомт нь Улаанбаатар хотоос 770 км, аймгийн төв Сайншандаас 320 км, Хатанбулаг сумын төвөөс 115 км-т Ханги боомт дээр байрлана.

Газарзүйн мужлал: Монгол орны физик газарзүйн мужлалаар төслийн талбай нь Төв азийн заримдаг цөл, Цөлийн их мужийн Дорнод говийн дэд мужид хамаардаг бөгөөд баруун болон хойд талаараа Хатанбулаг сумын багуудтай хиллэдэг ба урд талаараа БНХАУ-ын Мандал боомттой хиллэн оршдог.

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хэрэгжүүлэгч:

“Ханги Эко Логистик” ХХК

Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар:

0611008866

Регистрийн дугаар:

6980015

Хаяг:

Дорноговь, Хатанбулаг, 5-р баг, Аман-Ус, эргэл 1, 104 тоот

Утасны дугаар:

№:77310000


Хүснэгт 01. “Ханги эко логистик” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал
01.	Ж.Бямбасүрэн	“Ханги Эко Логистик” ХХК-ийн Гүйцэтгэх захирал
02.	Э.Хулан	“Ханги Эко Логистик” ХХК-ийн Захиргаа, хүний нөөцийн албаны дарга
03.	Б.Цэрэнтогтох	“Ханги Эко Логистик” ХХК-ийн ХАБЭА-БО-н инженер
04.	Ц.Мөнхтүвшин	“Ханги эко логистик” ХХК-ийн ХАБ-БО-ны мэргэжилтэн

1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн мэдээлэл

Тус Хатанбулаг суманд 2024 оны жилийн эцсийн байдлаар 987 өрхийн, 2,775 хүн оршин сууж байна. Үүнээс 53.2% буюу 1,478 нь эрэгтэйчүүд, 46.8% буюу 1,297 нь эмэгтэйчүүд байна. Хатанбулаг сумын хүн амын тоо 2024 онд 2,775 болж өмнөх оны мөн үеэс 2.7% буюу 78 хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Дорноговь аймаг нь нийт 109.5 мян.м2 км нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд засаг захиргааны 14 сум, 65 багаас бүрдэнэ. Тус аймагт 2023 оны жилийн эцсийн байдлаар 21,543 өрхийн, 71,414 хүн оршин сууж байна. Үүнээс 50.9 % буюу 36,372 нь эрэгтэйчүүд, 49.1 % буюу 35,042 нь эмэгтэйчүүд байна. Дорноговь аймгийн хүн амын тоо сүүлийн 5 жилд өссөн үзүүлэлттэй байсан хэдий ч 2023 онд 71,414 болж өмнөх оны мөн үеэс 0.5 % буюу 398 хүнээр буурсан байна.

Зураг 01. Ханги эко логистик ХХК-ийн “Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх төслийн талбайн байршил



1.4. Төсөл хэрэгжүүлэх шаардлага шалтгаан

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-д үндэсний тээвэр, логикийн тогтолцоог хөгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.6-д нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлэх, худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх экспортыг нэмэгдүүлэх, 3.1.18-д хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэх, Шинэ сэргэлтийн бодлогын 1.1-д боомтуудын хатуу зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх, 1.2-д хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн

холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэхээр тусгасан.

1. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1. **Газарзүйн мужлал:** Монгол орны физик газарзүйн мужлалаар төслийн талбай нь Төв азийн заримдаг цөл, Цөлийн их мужийн Дорнод говийн дэд мужид хамаарна. Төв азийн заримдаг цөл, цөлийн их муж нь 657,614.5 км² бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 42 хувийг эзэлдэг. Алтайн ар болоод өвөр говь, Говь-алтайн нуруу, говийн дорнод хэсэгт багтах бөгөөд гадарга нь урт удаан хугацааны туршид элэгдэл, эвдрэлд гүн өртсөн, цөлийн гандааст автан харлаж, өгөршлийн улмаас элдэв дүрс хэлбэртэй болсон, гадаргын ус ховор, гандуу хуурай уур амьсгалын нөхцөлд үүсэж тогтворжсон цөлжүү хээр, заримдаг цөл, хээржүү цөл, өмнөдийн цөл, хэт гандуу цөлийн ландшафт тархдаг. Энэ их муж нь Алтайн ар говийн, Говь-Алтайн бэлэрхэг уулын, Зүүнгарын говийн, Алтайн өвөр говийн, Дорнод говийн муж гэсэн үндсэн 5 муж, 12 дэд муж хэсгээс бүрдэнэ. Дорнод говийн муж нь Мандал овоо- Хулдын ухаа гүвээт тал, Мандал-овоо-Өлзийтийн цав толгод, Дэлгэрэх, Алтанширээгийн тал, Хатанбулаг-Хөвсгөлийн нам уулс, Галба-Шанхын уулс гэсэн үндсэн 5 дэд мужид хуваагдана. Нийт 233,468.2 км² буюу нийт нутаг дэвсгэрийн 15 хувийг эзэлнэ.

1.2. **Уур амьсгал:** Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Өвөлдөө агаарын температурын үнэмлэхүй их утга 33.6⁰хэм хүртэл хүйтэн боловч зундаа аагим халуун болдог байна. Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Дорноговь аймгийн зүүн хэсгээр жилийн дундаж агаарын температур 5.5⁰хэм, нутгийн хойд хэсгээр харьцангуй хүйтэн 0.3⁰хэм, бусад нутгаар 3.5-3.7⁰хэм дулаан байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур нутгийн хойд талаар 18.7⁰хэм, зүүн хэсгээр 21.3⁰хэм, төв болон өмнөд хэсгээр 23.1-24.0⁰хэм дулаан байна.

1.3. **Агаарын чанар:** Үнэмлэхүй хамгийн их температур Сайншанд, Хөвсгөл, Замын-Үүд орчмоор 41.8-42.4⁰хэм, Хатанбулагт 44⁰хэм хүрч халсан бөгөөд энэхүү үнэмлэхүй их утгууд нь 1991-2020 онуудын хооронд ажиглагдсан байна. Монгол орны ихэнх нутгаар 1991-2020 оны зуны хэт халалтын үеэр үнэмлэхүй их температур ихээхэн нэмэгдсэн билээ. Дорноговь аймгийн үнэмлэхүй хамгийн их температур нь нийт сумуудын хувьд 39.6-44.3⁰хэм хооронд бүртгэгдсэн байна

1.4. **Гадаргын ус:** Төслийн талбай нь гидрогеологийн мужлалаар Өмнөд Монголын гидрогеологийн системийн улирлын хомс тэжээгдэлтэй мужид хамаарах бөгөөд Дорноговь болон Галбын говийн газар доорх усны сав газарт багтдаг. Эдгээр сав газар нь газар доорх усны ихээхэн хуримтлал үүсгэхүйц байгалийн тааламжтай нөхцөл туйлын ховор бөгөөд сүүлийн үед олон жилийн турш уул уурхайн олборлох үйлдвэр, хүн амын бөөгнөрлөөс хамаарч газар доорх усны нөөцийн хомсдол цэгэн шинжтэй илрэх болсон.

1.5. **Газрын доорх ус:** Төслийн талбай нь газрын доорх усны нөөцийн тархалтаар газрын доорх урсцын түвшин жилд < 5 мм байна. Цэрд, пермийн настай тунамал хурдас нь “Нуур-эх газрын гаралтай усжилт, ундарга багатай, 0.03-0.1 л/с/км² нөөцтэй” мужид хамаарагдана. Дөрөвдөгчийн хурдас нь “тун бага усжилттай буюу 0.003-0.03 л/с/км² нөөцтэй” гэсэн ангилалд Н.Жадамба-ын зургийн дагуу хамааруулсан байна. “Ханги Эко Логистик” ХХК-ийн Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх төслийн талбай нь гидрогеологийн мужлалаар Өмнөд Монголын гидрогеологийн системийн улирлын хомс тэжээлтэй мужийн Дорноговийн дүүрэгт хамаарагдах бөгөөд гадаргуугийн усан сүлжээ, усны

хангамжаар хангагдаагүй буюу хомс хангагдсан мужид хамаараагддаг байна. Эдгээр ай савууд нь газар доорх усны ихээхэн хуримтлал үүсгэхүйц байгалийн тааламжтай нөхцөл туйлын ховорын дээр сүүлийн олон жилийн турш уул уурхайн олборлох үйлдвэр, хүн амын бөөгнөрлөөс зонхилон хамаарч газар доорх усны нөөцийн хомсдол цэгэн шинжтэй илрэх болсон онцлогтой байдаг байна.

1.6. **Хөрс:** Төслийн талбай нь нийт 33.5 га бөгөөд талбайн хүрээнд нам ухаа гүвээ болон тэдгээрийн хоорондох хөндий, хуурай сайр бүхий д.т.д 1185-1200 м өндөртэй газарт байрлана. Төслийн талбайд Монгол орны хөрсний ангиллаар Бор хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, сайргархаг ба элсэн төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-30 см), хэврэг өрмөцөр болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэргүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж маш сул байдаг онцлогтой. Мөн чулуурхаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн Bca-BCca-Cca гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж дээд үе давхаргад 1.0 -1.2%, бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 8.2-8.8 буюу дунд зэргээс хүчтэй шүлтлэг, хялбар уусах давсжилт талхадсан сайргархаг Бор хөрсний доод үе давхаргад их (1.5 dS/m) агууламжтай, бусад хөрсөнд маш бага буюу 0.11-1.16 dS/m байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр бүрэлдэхүүнтэй, нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна.

1.7. **Ургамал:** Ургамал-газарзүйн мужлалаар цөлийн бүсэд нийтдээ 497 зүйл ургамал бүртгэгдсэний дотор өвслөг ургамал 389 зүйл буюу 78.27 хувь, модлог сөөглөг ургамал 108 зүйл буюу 21.73 хувь байна. Модлог ургамлаас сөөг, сөөгөнцрийн бүлгэмдэл зонхилж тоорой, хайлаас, жигд, заг зэрэг мод ургах ба баянбүрд даган тоорой, хэд хэдэн зүйл сухай элбэг. Цөлийн ургамлын бүрэлдэхүүнд хуурайсаг, хуурайсуу-чулуусаг, элслсэг зэрэг ганд тэсвэртэй ургамал зонхилно (Өлзийхутаг, 1989).

1.8. **Амьтан:** Амьтны аймгийн газарзүйн мужлалын хувьд Говийн амьтны аймгийн үүсэл гарлын хувьд эртний бөгөөд Төв Азийн амьтны аймгийн үүслийн үндсэн голомтын нэг гэж тооцогддог. Төслийн 4 зүйлийн хөхтөн амьтныг ажигласан. Үүнд хар сүүлт зээр (N=7), цагаан зээр (N=42), Хулан (N=116), морин чичүүлийн хэд хэдэн бүл байна. Эдгээр 4 зүйлээс 3 нь буюу хулан, хар сүүлт, цагаан зээр нь Олон улсын хэмжээнд болоод бүс нутгийн хэмжээнд Устаж болзошгүй, Ховордож болзошгүй, Монгол улсын Улаан номд ховор ангиллаар тус тус бүртгэгдсэн зүйлүүд юм

1.9. **Нийгэм, эдийн засгийн байдал:** Дорноговь аймаг нь нийт 109.5 мян.м²/км нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд засаг захиргааны 14 сум, 65 багаас бүрдэнэ. Төслийн талбай нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 4-р баг (Сулинхээр)-т байрлана. Тус багт 2023 оны жилийн эцсийн байдлаар 198 өрхийн, 572 хүн оршин сууж байна. Үүнээс 52.2 % буюу 299 нь эрэгтэйчүүд, 50 % буюу 273 нь эмэгтэйчүүд байна. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Сулинхээр багийн хүн амын тоо 2023 онд 572 болж өмнөх оны мөн үеэс 3.8 % буюу 23 хүнээр буурсан үзүүлэлттэй байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СЭРЭГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол зорилт

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дүгээр сарын 11 -ны өдрийн “Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн терминал байгуулах тухай” 376 дугаар тогтоолоор КОВИД-19 цар тахлын үед экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нүүрсний экспорт бүхий хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг

нүүрс олборлон экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн байна.

Тус шийдвэрийн хүрээнд Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх төсөлтэй холбоотой санхүүжилтийн нийт зардлыг “Ханги эко логистик” ХХК хариуцан санхүүжүүлэхээр тохиролцсон байна.

Уг төсөл нь Чингэлгийн тээврээр нүүрс тээвэрлэх, хадгалах, ачиж буулгах зэрэг үйл ажиллагаанд үүсэх хорогдлыг бууруулах, нүүрсний чанар алдагдуулахгүйгээр байгаль орчин, жолооч нарт ээлтэй, эдийн засгийн үр ашигтай экспортын хэмжээг нэмэгдүүлэх юм.

Ханги эко логистик ХХК нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд өөрийн эзэмшлийн 33.5 га талбайд хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг системийг нэвтрүүлж, өөрийн чингэлэг тээврийн ухаалаг системээр дамжуулан Монгол Улсын экспортыг улам бүр нэмэгдүүлэхэд тасралтгүй, хүний оролцоогүйгээр тээвэр зохион байгуулалтыг хийх, тээвэр, логистикийн орчин үеийн технологийг цаг алдалгүй нэвтрүүлэхэд төслийн зорилго оршино.

Цар хүрээ, хэмжээ

Төслийн нэр: Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн терминал байгуулах:

Төслийн захиалагч байгууллага: “Ханги эко логистик” ХХК

Төсөл хэрэгжүүлэгч, өмчлөгч байгууллага: Төр, хувийн хэвшлийн түншлэл

- 3.2. **Төсөл захиалагч байгууллагын хаяг:** Дорноговь, Хатанбулаг, 5-р баг, Аман- Ус, эргэл 1, 104 тоот
- 3.3. **Төслийн байршил:** Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн терминал байгуулах төслийн талбай нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Сулинхээр 4-р багт байрлана.
- 3.4. **Төсөл хэрэгжсэнээр:**
 - Төслийн хүрээнд усны нөөц ашигласны, нийгмийн даатгал, аж ахуйн нэгжийн орлогын зэрэг татвар, хураамж хэлбэрээр улс орон нутгийн төсөвт татвар хураамж төвлөрүүлж улс орон нутгийн эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ.
 - Орон нутгийн дэд бүтцийн салбар, нийтийн аж ахуй, нийгмийн үйлчилгээ зэргийг сайжруулахад орон нутагтай хамтран ажиллах, хөрөнгө оруулалтаар дамжуулан орон нутгийн хөгжилд эергээр нөлөөлөх
 - Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг аймгийн Сайншанд болон Хатанбулаг сумаас хангаснаар орон нутгийн эдийн засгийн эргэлтэд эергээр нөлөөлөх
 - Олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх төсөл амжилттай хэрэгжсэнээр орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийн тусламжтайгаар ачаа барааг хил дамнуулан тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, гааль бүрдүүлэлтийн систем хөгжихөд хувь нэмэр оруулна.
 - Монгол улсын нүүрсний болон бусад ачаа тээврийн экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.
 - Хүнээс үл хамаарах тээвэр зохион байгуулалт хийх боломж бүрдсэнээр цар тахлын үед ч тасралтгүй нүүрсний экспортыг зохион байгуулах боломж бүрдэнэ.
 - Уурхайн амнаас эцсийн хэрэглэгч хүртэл битүүмжилсэн чингэлэг тээвэрлэлт хийгдэх боломж бүрдэнэ.
 - Хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх төслийн хүрээнд нийт 101 хүнийг шууд ажлын байраар хангаж, туслан

гүйцэтгэгч байгууллагуудын ажилчдыг дам байдлаар ажлын байраар хангаснаар нутгийн ажиллах хүчний тоо нэмэгдэх

- Төсөл хэрэгжсэнээр орон нутагт шилжин суурьших хүн амын тоо өсөж, төвлөрөл нэмэгдэх, үүнтэй холбоотойгоор төрийн болон нийгмийн үйлчилгээний (эмнэлэг, цагдаагийн алба, сургууль, цэцэрлэг гэх мэт) ачаалал нэмэгдэх, хүртээмж буурах
- Төслийн түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх авто зам, замын ашиглалттай холбоотой замын хөдөлгөөний аюул, осол авар гарах
- Төслөөс үүдэлтэй хүн амын нягтрал ихэссэнээр халдварт өвчний тохиолдлын тоо ихсэх
- Төслөөс үүдэлтэй болзошгүй нөлөөлөл (дуу шуугиан, замын тоос, агаарын бохирдол, тээврийн хөдөлгөөн гэх мэт) иргэдэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Нүүрс хүлээн авах уурхайгаас ирэх нүүрсийг битүү чингэлэгт шилжүүлэн ачсанаар задгай тэвшинд ачсанаас үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлнэ

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Ханги эко логистик ХХК нь 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2024 онд “Баялаг эко” ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

4.1 “Ханги эко логистик” ХХК нь 2025 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд нийт **39,940,000** төгрөг зарцуулахаар төлөвлөвөө.

№	Хийгдэх ажлын чиглэл	Нийт зардал,
4.2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10,900,000
4.3	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	5.100.000
4.4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5.400.000
4.6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	12,480,000
4.7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4,560,000
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,500,000
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	
Нийт		39,940,000

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
4.2.1	Барилгын газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Барилгын ажлын үед тоосжилт үүсэх газар шорооны ажлын үед усалгааг тайланд тусгасан усалгааны аргаас сонгон ашиглах	Барилгын ажлын талбай	Нэгж усалгаа	Үйл ажиллагааны зардалд тусгах			Барилгын ажлын хугацаанд	MNS 4585:2016. Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага MNS ISO 4227- 2002 Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 6598:2023
4.2.2		Барилгын ачаа тээвэрлэлтийг авто машинаар гүйцэтгэх үед хурдны хязгаарт хяналт тавих тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Тээврийн зам	ш	700.0	20 тэмдэг 5 самбар	3,500,000	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
4.2.3		Терминалын талбай, гаалийн талбайг дэд бүтцийн хатуу хучилттай болгох	Төслийн талбай	Хөрөнгө оруулалтын зардалд тусгах				Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	

4.2.4	Төслийн үйл ажиллагаагаар нийт 33.5 га талбайн шимт хөрс хуулна.	Шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хуулж тусад хадгалах	Төслийн талбай	м 3	Үйл ажиллагааны зардалд тусгах			Үйл ажиллагааны турш	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт
		Шимт хөрсний овоолгын ойр орчимд тэмдэг тэмдэглэгээг хийх	Шимт хөрсний овоолго	Овоолго	2	200.000	400.000	Жилийн турш	
4.2.5	Төслийн бүтээн байгуулалтын үеийн ус ашиглалт.	Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэгийг тоолууржуулах бөгөөд шугам хоолой бүрийн тоолуурын баталгаажуулалт, түүний хяналтыг хийх	Төслийн талбайн уст цэгүүд	ш	2	1.0	2.0	Жилийн турш	Усны тухай хууль MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
		Усны ерөнхий шинжилгээний хариугаар худгийн ус нь унд ахуйд ашиглахад хатуулаг ихтэй гарсан тул зөөлрүүлэх, цэвэршүүлэх төхөөрөмж тавих, шаардлагатай үед сольж байх	Төслийн талбай	ш	1	5.0	5.0	Жилийн турш	

4.2.6	Барилгын ажлын үед газрын доорх ус нэвчин гарч болзошгүй	Усны ундаргыг нарийвчлан тооцож, усыг шүүрүүлэн шавхан зайлуулах барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилийн турш	
4.2.6	Төслийн хүрээнд бий болох төмөр замаас шалтгаалан амьтдын амьдрах орчин хуваагдах	Төслийн хүрээнд бий болох төмөр замын дагуу 2 ширхэг зэрлэг амьтан нэвтрүүлэх нүхэн гарцыг стандартын дагуу хийх, хориг хашааг байгуулахдаа амьтанд ээлтэй байдлаар хийх	Төслийн талбай	ХОЗ	2025 онд	
4.2.7	Төслийн талбайд байрлах цахилгааны шугамын хийцээс шалтгаалан шувууд үрэгдэх	Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шувуудад ээлтэй буюу тог тусгаарлагчтай, шувуу үргээгч төхөөрөмжтэй байхаар төлөвлөх,	Төслийн талбай	ХОЗ	2025 онд	
4.2.7	Ажилчдын унд ахуйн хэрэглээний бохир ус хөрс бохирдуулж болзошгүй	Септик системийн зөөврийн цэвэрлэх байгууламж суурилуулах	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	

4.2.8	Хог хаягдлыг стандарт шаардлага хангаагүй нөхцөлд хадгалсан тохиолдолд ойр орчмын хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй	Хог хаягдлын дотоод журмыг боловсруулан ажиллах. Энгийн ба аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хадгалан, хог хаягдлыг тогтмол эрх бүхий байгууллагаар ачиж тээвэрлүүлэх.	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		Үйл ажиллагааны турш	MNS 3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
4.2.9	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Мод тарих	Орон нутгаас санал авах	ш	Үйл ажиллагааны зардалд тусгах	50	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
	Нийт					10,900,000			

4.3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
4.3.1	Тариалах үр, суулгац авах	Одой хайлаас	Төслийн талбай	ш	50	20.0	1,000,000	10-р сард	
4.3.2	Тариалах талбайг бэлдэх	Бордоо ашиглан хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх	Төслийн талбай	кг	50	30,0	1,500,0	10-р сард	
4.3.3		Бууц элс нэмэх	Төслийн талбай	м ²	40	40.0	1,600,0	10-р сард	
4.3.4	Тариалалт хийх	Ажилчдын хөлс, машин техникийн зардал	Төслийн талбай	хүн	5	Үйл ажиллагааны зардалд тусгах		10-р сард	
4.3.5	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, тордлогоо хийх	Одой хайлаас	Төслийн талбай	Литр	40	Үйл ажиллагааны зардалд тусгах		Дулааны улиралд	
	Нийт					5.100.000			

4.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Соёлын өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгал бүхий өвийг ойлгоно. Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутгийнхаа түүх, соёлын өвийг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилгоор соёлын өвийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
4.4.1	Биет болон биет бус өв	Ажилчдад Соёлын өвийн зааварчилгаа өгөх, дурсгалт зүйлс олдох үед баримтлах сургалт орох	Төслийн талбайд ажиллах нийт ажилчид	Нийт ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах		Улирал бүр	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
	Нийт							

4.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
4.5.1	Үер	Төслийн эзэмшил талбайг хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахаас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн талбай	-	Хөрөнгө оруулалтын зардалд		Бүтээн байгуулалтын үед	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм

4.5.2	Аянга цахилгаан	Аянга газардуулагчийг байрлуулах		Ш			MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм
		Төслийн талбайд аянга, цахилгаан газардуулах тоноглолуудыг байгуулах, бүрэн байдал болон газардуулгын эсэргүүцлийн хэмжилт хийлгэж байх					
4.5.3	Газар хөдлөлт	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлтийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах	Ханги Эко Логистик ХХК	2	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны үед	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга

4.5.4	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж төслийн талбайд байршуулах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Төслийн талбай	5 ш галын сараа 10 ш галын хор	галын сарайны багц 2.0 галын хор 0.2	9.8	Үйл ажиллагааны турш	MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй.
		Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсад сургалт зохион байгуулах	Ханги Эко Логистик ХХК	1	ХАБЭА-н зардалд тусгах		Жилд 1 удаа	Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага. MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ. MNS 4992:2000 Хөдөлмөрийн эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
4.5.5	Аюулгүй ажиллагаа алдагдах	Ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан хувцас, Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах	Төслийн ажилчид	-	Үйл ажиллагааны ХАБЭА-н зардалд тусгах		Үйл ажиллагааны турш	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ. MNS 4992:2000 Хөдөлмөрийн эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
		Жолооч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Жолооч нарт	-	Үйл ажиллагааны ХАБЭА-н зардалд тусгах		Үйл ажиллагааны турш	
		Анхны тусламжийн эмийн сангийн хайрцгийг байршуулах	Ажилчдын оффис, нэг цэгийн үйлчилгээний цэг	2	200.000	400.000	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	
4.5.6	Автомашины осол аваараас сэргийлэх	Машин, техник хэрэгслийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх	Тээврийн жолооч нар	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		Үйл ажиллагааны турш	
	Нийт					5.400.000		

4.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
4.6.1	Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг төслийн талбайд байршуулах	Төслийн талбай	ш	1.0	5	5,000,000	2025 онд	Хог хаягдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга) Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
		Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгах цэг байгуулах	Төслийн талбай	ш	2,000,0	1	2,000,000	2025 онд	
		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг аймгийн хог хаягдал дахин боловсруулах төсөл хөтөлбөр, үйлдвэрт нийлүүлэх	Төслийн талбай	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах			Жилд 1-2 удаа	
		Ангилан ялгаж буй хог хаягдлаа гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	удаа	40.0	12	480.000	Сар бүр	

		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбайн дотоод, гадаад 50 м зайд	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд 2 удаа	
--	--	---	--	------	--------------------------------	-------------	--

4.6.2	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг ангилж ялган, зориулалтын сав болон тэмдэг тэмдэглэгээтэй цэг байгуулах	Төслийн талбай	ш	5.000.0	1	5.000.0	2025 онд	
	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах шилжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналтыг тавьж, бүртгэл хөтлөх	Ханги Эко Логистик ХХК	-	Үйл ажиллагааны зардалд тусгах			Сард нэг	
		Машин техникийн ШТМ, фильтр зэрэг аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэх устгуулах	Төслийн талбай	кг	Үйл ажиллагааны зардалд тусгах			Улирал бүр	
	Нийт							12,480,000	

4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Д/д	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Хугацаа ба давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР								
Агаарын чанар								
4.7.1	Орчны тоосжилт (PM2.5 , PM10 TSP) 1. • Агаарын температур • Харьцангуй чийг • Гадаад болон дотоод орчны дуу чимээ	Уурын зуух, дизель генераторын хажууд, Чингэлэг буулгах талбай, Автомашины зогсоолын хажууд	4	Улиралд 1 удаа	350.0	0.35 * 4 удаа = 1.4		MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага. MNS 4048:1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга.
Усан орчин								
4.7.2	Ерөнхий хими, физикийн шинжилгээ	Худаг-1 Худаг-2	Улиралд 1 удаа	4 удаа	100.0	0.1*4 улирал=0.4		MNS ISO 5667:11:2001 Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж. MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Хөрсний хими болон физик								
	Нийт							4,560,000

Д/д	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Хугацаа ба давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР								
Агаарын чанар								
	Орчны тоосжилт (PM2.5 , PM10 TSP) • Агаарын температур 4. • Харьцангуй чийг • Агаар бохирдуулагчий (SO2, NO2,) • Гадаад болон дотоод орчны дуу чимээ	Уурын зуух, дизель генераторын хажууд, Чингэлэг буулгах талбай, Автомашины зогсоолын хажууд	4	Жилд 1 удаа	350.0	350.0		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
Ургамлан нөмрөг								
4.7.5	-Ургамлын зүйлийн бүрдэл -Ургамлын нөмрөгийн бүрхэц	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	-	Жилд 1 удаа	1.000.000	1.000.000		MNS ISO 5667:11:2001 Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж. MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Хөрс, газрын гадарга								

4.7.6	<p>Ялзмаг</p> <ul style="list-style-type: none"> • Урвалын орчин (pH) • Карбонат, нитрат, фосфор, кали • Давсжилт 	<p>Уурын зуух, дизель генераторын хажууд, Автомашины талбайн хажууд, AGV граж засварын төвийн хажууд,</p>		<p>Жилд 1 удаа 1 дээж</p>	<p>Жилд 1 удаа 1 дээж 60.0*2 цэг = 120.0</p>	120,000		<p>MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6341:2012 Хөрсний чанар. Хөрсөнд эрүүл зүйн Няг судлалын шинжилгээ хийх арга MNS 2305:1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам</p>
-------	--	---	--	---------------------------	--	---------	--	---

Амьтны аймаг

4.7.7	<ul style="list-style-type: none"> • Амьтны нүүдэл шилжилтийн мониторинг • Амьтаны тоо толгой 	Төслийн талбай болон түүний ойр орчим	-	Жилд 1 удаа	1.000.000	1.000.000		
	Нийт							2,470,000

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			20.. он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2	3	4	5	6	7	
5.1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Хөрөнгө оруулалтын зардалд тусгах	Үйл ажиллагааны туршид			Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	
5.2	Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	1.500.000	Үйл ажиллагааны туршид жил бүр			Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	
5.3	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдын ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалтын хэрэгслээр тогтмол хангах	Хөрөнгө оруулалтын зардалд тусгах	Жилд 1 удаа			Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	

5.4	Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн ус ашиглалт, хаягдал ус хаях, зайлуулахтай холбоотой мэдээллүүдийг усны газрын мэдээллийн санд бүртгүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд 1 удаа	Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	
5.5	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвөлгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд 1 удаа	Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	
5.6	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	2,0	2 жил тутамд нэг удаа	Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	
	Нийт				1.500.000

6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧ+ДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад хэлэлцүүлэх байгууллагуудад	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/а жилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
6.1	Дорноговь аймгийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн газар	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс өмнө	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, санал авах	Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн	Дорноговь аймгийн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн газарт
6.2	Хатанбулаг сумын ЗДТГ-г	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах		Жил бүрийн 11 дүгээр сарын 01 нээс өмнө			Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-г
6.3	Төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам/	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төлөвлөгөөтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.		Жил бүрийн 12 дугаар сарын 30- наас өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгах		Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам-д
	Нийт						

